



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 18 нэрийн, нийт 3,023,782,000.00 (гурван тэрбум хорин гурван сая долоон зуун наян хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,483,150,000.00 (нэг тэрбум дөрвөн зуун наян гурван сая нэг зуун тавин мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алимаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



өмчийн бодлого, зохицуулалтын
 2024 оны 05 дугаар сарын 20 ө
 260 дугаар тогтоолын хар
 нгөд
 100Х ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Гэрэлтүүлэг хэмжигч багаж	10/1/2008	1	283,800.00	283,800.00	100,000.00	100,000.00	3
2	Шуугиан хэмжигч багаж	10/1/2008	1	451,000.00	451,000.00	200,000.00	200,000.00	3
3	Тоосны сорьц цуглуулах багаж /Гэмтэл согог илрүүлэгч/	12/9/2013	1	7,628,400.00	7,628,400.00	3,500,000.00	3,500,000.00	3
4	Air conditioner /хана/	11/20/2018	3	955,000.00	2,865,000.00	450,000.00	1,350,000.00	3
5	Сервер-1	12/31/2018	6	42,058,500.00	252,351,000.00	20,000,000.00	120,000,000.00	3
6	Сервер-2	12/31/2018	4	31,241,650.00	124,966,600.00	15,000,000.00	60,000,000.00	3
7	Өгөгдөл хадгалах төхөөрөмж	12/31/2018	4	44,123,200.00	176,492,800.00	20,000,000.00	80,000,000.00	3
8	Свич	12/31/2018	4	23,557,600.00	94,230,400.00	11,000,000.00	44,000,000.00	3
9	Галт хана	12/31/2018	4	57,758,250.00	231,033,000.00	25,000,000.00	100,000,000.00	3
10	Серверийн үйлдлийн систем-1	12/31/2018	8	2,110,350.00	16,882,800.00	1,000,000.00	8,000,000.00	3
11	Серверийн үйлдлийн систем-2	12/31/2018	8	4,066,700.00	32,533,600.00	2,000,000.00	16,000,000.00	3
12	Серверийн үйлдлийн систем-3	12/31/2018	6	7,061,450.00	42,368,700.00	3,500,000.00	21,000,000.00	3
13	Explorer 3.16	6/12/2001	1	1,540,000.00	1,540,000.00	1,000,000.00	1,000,000.00	5

14	Серверийн виртуалчлалын удирдлагын програм	12/31/2018	2	22,015,950.00	44,031,900.00	11,000,000.00	22,000,000.00	3
15	Серверийн виртуалчлалын програм хангамж	12/31/2018	28	15,837,250.00	443,443,000.00	7,500,000.00	210,000,000.00	3
16	Өгөгдлийн сангийн удирдлагын систем-1	12/31/2018	8	145,487,100.00	1,163,896,800.00	72,000,000.00	576,000,000.00	3
17	Өгөгдлийн сангийн удирдлагын систем-2	12/31/2018	8	33,097,900.00	264,783,200.00	15,000,000.00	120,000,000.00	3
18	Ландкрийзер-200 V6 (улсын дугаар 01-16УБА)	1/1/2014	1	124,000,000.00	124,000,000.00	100,000,000.00	100,000,000.00	5
Нийт дүн					3,023,782,000.00		1,483,150,000.00	
					(гурван тэрбум хорин гурван сая долоон зуун наян хоёр мянга)		(нэг тэрбум дөрвөн зуун наян гурван сая нэг зуун тавин мянга)	